

ТАНИЛЦУУЛГА

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх журмын талаар

“Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх журам”-ын төслийг боловсруулахад БНСУ, Япон, ХБНГУ, Тайланд улсын хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, судалгааны тайлан болон дотоодын хууль тогтоомж, журам, нийтлэл, судалгааны тайлан, олон улсын сайн туршлагыг судалсан.

Түүнчлэн “Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөмтгий болон тэсвэртэй байдлын суурь судалгаа” судалгааны тайлан, Конарад Аденаур сангийн тусламжтайгаар гүйцэтгэсэн “Ази болон Европын орны хүн худалдаалах гэмт хэргийн туршлага” судалгааны тайлан, Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх өмгөөлөгчийн гарын авлага, Азийн сангийн захиалгаар гүйцэтгэсэн “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод туслалцаа үзүүлэх үндэсний механизмын зураглал”, НҮБ-ын хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх газрын “Хүн худалдаалах гэмт хэргийн загвар хууль” судалгааны тайлан, дотоодын болон гадаадын хууль тогтоомж, FLEX-ын “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн хохирлыг барагдуулах” тайлан зэргийг ашигласан.

Улс орнууд хууль зүйн туслалцааг бүрэн гүйцэт, чанартай болон цаг тухайд нь үзүүлээгүй эсхүл хууль зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзсан нөхцөлийг засан сайжруулж, үүнтэй холбоотойгоор учирсан хохирлыг нөхөн төлж, барагдуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх үүрэгтэй. НҮБ-ын зарчим, зөвлөмжийн хүрээнд чанартай хууль зүйн туслалцаа гэдэгт юуг ойлгож хэрэглэх тухай тодорхойлоогүй ч гэсэн гишүүн улс орнууд хууль зүйн туслалцааны үйлчилгээний чанарыг цаг ямагт сайжруулж, боловсронгуй болгох үүрэгтэй гэж зохицуулжээ.

Нэг. Журмын төсөл боловсруулсан зорилго, ач холбогдол

“Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх журам”-ын төсөл боловсруулсан зорилго нь Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хууль тогтоомжид зааснаар хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хууль зүйн туслалцаа цаг алдалгүй, нэн даруй үзүүлэх, НҮБ-ын зарчим, зөвлөмжийн дагуу хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хууль зүйн туслалцааг үзүүлж хохирогчийн эрх ашгийг хууль ёсны дагуу хамгаалахад оршино.

“Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хууль зүйн туслалцаа үзүүлэх”-ийн төслийн ач холбогдол нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хууль зүйн туслалцааг үзүүлснээр хууль зүйн туслалцааны төв, өмгөөлөгч болон төрийн бус байгууллагууд нь хохирогчид ээлтэйгээр асуудлыг шийдвэрлэхэд тусалж, хохирогчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалан ажиллахад оршино.

Хоёр. Журмын төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа

“Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх журам”-ын төсөл 8 зүйл, 20 хэсэг, заалттай байна.

“Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх журам”-ын төсөл нь нэгдүгээр зүйлд нийтлэг үндэслэл, хоёрдугаар зүйлд хохирогчид үзүүлэх хууль зүйн туслалцааны зарчим, гуравдугаар зүйлд хохирогчид үзүүлэх хууль зүйн туслалцааны төрөл, дөрөвдүгээр зүйлд хууль зүйн зөвлөгөө өгөх, тавдугаар зүйлд өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх, зургаадугаар зүйлд хохирогч хүүхдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх, долоодугаар зүйлд хууль зүйн туслалцаа үзүүлэхэд дэмжлэг үзүүлэх төрийн бус байгууллагын чиг үүрэг, наймдугаар зүйлд бусад зүйл гэсэн ерөнхий бүтэцтэй байна.

Энэхүү журмын нийтлэг үндэслэл гэсэн нэгдүгээр зүйлд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах ба уг журам нь Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, Хууль зүйн туслалцааны тухай хууль, Өмгөөллийн тухай хууль, Хуульчин эрх зүйн байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомж, стандартад нийцсэн байх, хууль зүйн туслалцааны төрлийг харгалзахгүйгээр энэхүү журмыг дагаж мөрдөхөөр тусгасан.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх хууль зүйн туслалцааг үзүүлэхдээ мөрдлөг болгох зарчмыг тусгасан. Тухайлбал: Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 4.1.4, 4.1.5, 4.1.6 дугаар зүйлд заасан зарчим болон хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэхдээ хохирогчийн эрх чөлөөг хүндэтгэх, нууцыг хадгалах, хууль зүйн туслалцаа нь үр нөлөөтэй байх, мэргэшсэн тогтвортой байх, хууль ёсны ашиг сонирхлын хүрээнд тууштай хамгаалах гэсэн зарчмуудыг үйл ажиллагаандаа удирдлага болгохоор тусгаж өгсөн.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх хууль зүйн туслалцааны төрөл гэсэн гуравдугаар зүйлд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх хууль зүйн туслалцаа нь хууль зүйн зөвлөгөө өгөх, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх гэсэн хоёр төрөлтэй байхаар тусгасан. Түүнчлэн Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн хохирогчид энэхүү журам үйлчилнэ.

Хууль зүйн зөвлөгөө өгөх гэсэн дөрөвдүгээр зүйлд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх хууль зүйн туслалцааны зөвлөгөөг ямар хэлбэрээр зөвлөгөө, мэдээлэл өгөх, хууль зүйн ач холбогдол бүхий бичгийн эх боловсруулах түүнчлэн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төлбөрийн чадвартай тохиолдолд хууль зүйн зөвлөгөөг авах байгууллага болон хууль зүйн зөвлөгөө өгөхдөө анхаарах зүйлийн талаар тусгасан.

Өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх гэсэн тавдугаар зүйлд өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх нийтлэг эрх, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх байгууллага, өмгөөлөгчтэй холбон зуучлах албан тушаалтан, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэхдээ хохирогчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор дэмжлэг авч болох байгууллагыг тодорхойлсон.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэхээр.

Хууль зүйн туслалцаа үзүүлэхэд дэмжлэг үзүүлэх төрийн бус байгууллагын чиг үүрэг гэсэн долоодугаар зүйлд төрийн бус байгууллагын үйл ажиллагаа, чиг үүрэг, эрх, үүргийн талаар тусгасан.

Бусад зүйлд энэ журмыг зөрчсөн тохиолдолд хэрхэн шийдвэрлэх талаар тусгасан.

--oOo--